



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 БАГА БОЛОВСРОЛ

5
АНГИ

МОНГОЛ ХЭЛ

БАГАНАН КОД
НААХ ХЭСЭГ

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

Засалтын хүснэгт

| Даалгаврын дугаар | Авсан оноо |
|-------------------|------------|
| I | |
| II | |
| III | |
| IV | |
| V | |
| VI | |
| VII | |
| VIII | |
| IX | |
| X | |
| XI | |
| XII | A |
| | Б |
| | В |



САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Цэвэр гаргацтай бичээрэй.
- Эхийг уншаад, даалгаврыг зааврын дагуу гүйцэтгээрэй.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. УНШИХ

Хулгана ном хоёр

Гэрийн хаягаар орж ирсэн хулгана шууд л орны хөндийд навсайж хэвтсэн хүрэн цүнх рүү шургачихлаа. Цүнхэн дотор тас харанхуй. Тэнд ганц ном, хоёр дэвтрээс өөр юу ч байсангүй. Хулгана номын булангаас өм татан хазтал ном учиргүй чанга ёлон,

- Чи яасан өрөвдөх сэтгэлгүй амьтан бэ? Өдөржин харанхуй саванд хэвтэж нэг уйлах, чамд зулгаалгаж бас нэг өвдөх хэцүү еэ.
- Үгүй ер дөө, харж хандах эзэнгүй чамайг хазаж хэмлэхэд яадаг юм гээд хулгана дахин ухасхийвэл ном хатуу хавтсаа гэнэт дэлгэж, хамар дундуур нь буулгаад авчээ.
- Чадал ихтэй ном байх нь ээ. За яах вэ? Ноохойлох цаас мундсан биш гээд хулгана гарахыг завдтал ном араас нь дуудаж,
- За за битгий гомд л доо. Одоо хоёулаа эвлэрье. Харин чи миний эзнийг эрдэм номоо өөд татдаг болгоход туслаач гэв. Ийнхүү ном хулгана хоёр танилцан, сайн нөхөд болж, салан сургач Онхооныг гайгүй сайн ичээж хашраахаар тохиролцжээ.

Амралтын өдөр гялсхийн өнгөрч, хичээлийн шинэ долоо хоног эхэллээ. Хонх жингэнэн дуугарч, багш орж ирэв. Онхоон дэвтрээ авахаар гараа шургуултал нэг жижигхэн юм хөдлөх шиг болов. Цочсондоо ухасхийн босвол цүнхнээс нь хулгана гараад зугтах нь тэр.

Анги дүүрэн шуугиан дэгдэж, зарим охид айсандaa ширээн дээр гарч, хөвгүүд хулганы араас хөөх гэтэл багш байсан тул яаж ч чадсангүй. Дэний л суудлаасаа “Тэр байна, тэр байна” гэж хаширалдана. Үйл явдал хоромхон зуур болж, ашгүй ангиас эсэн мэнд гарч амжлаа. Онхоон ичсэндээ чих нь хүртэл улайжээ. Үүнээс хойш тэр цүнхтэй номоо хaa хамаагүй хаяхаа байсан гэдэг шүү.



1 Хулгана хэний цүнхэнд орсон бэ?

- | | |
|---------------------------|--------------------------|
| A. Эзэн нь тодорхойгүй | B. Сургуулийн сурагчийн |
| C. Онхоон гэдэг сурагчийн | D. Ойдов гэдэг сурагчийн |

2 Ном яагаад хулганаас тусламж гүйсан бэ?

- | |
|--|
| A. Эзэн нь хичээлээ хийдэггүй болохоор |
| B. Эзэн нь номоо урдаг болохоор |
| C. Эзэн нь цүнхээ угааж хэрэглэдэггүй болохоор |
| D. Эзэн нь цүнхээ хaa хамаагүй хаядаг болохоор |

3 Эхэд юуны тухай өгүүлсэн бэ?

- | | |
|---------------------------------|--------------------------------------|
| A. Уранхай номын тухай өгүүлсэн | B. Хүрэн цүнхэнд болсон явдлын тухай |
| C. Сэргэлэн хулганы тухай | D. Салан задгай сурагчийн тухай |



4

Ном, хулгана хоёрын үг яриа, үйдлийг уран дүрслэлийн ямар аргаар илэрхийлснийг тодорхойлж бичээрэй.

5

Сурагч Онхоон юунаас болж ичсэн бэ?

6

Зохиогч цүнхийг орны хөндийд байгаагаар бичсэний шалтгаан нь юу вэ?

7

Уран сэтгэмжийг илэрхийлсэн өгүүлбэрийг олж тэмдэглээрэй

Онхоон ичсэндээ чих нь хүртэл улайжээ.

Ном хатуу хавтсаа гэнэт дэлгэж, хамар дундуур нь буулгаад авчээ.

Онхоон дэвтрээ авахаар гарала шургуултал нэг жижигхэн юм хөдлөх шиг болов.

Яагаад уран сэтгэмж гэж үзсэн бэ?

8

Онхоонд тохиолдсон явдлаар дамжуулан зохиогч бидэнд ямар сургамжийг өгсөн бэ?

9

Онхооны зан чанарын өөрчлөлт нь хулгана, ном хоёрын ямар үйл хөдлөлөөс шалтгаалсан бэ?



ХОЁРДУГААР ХЭСЭГ. БИЧИХ


- 10 Өгүүлбэрийн тодруулсан үг аль дүрэмд хамаарах вэ? тэмдэглээрэй.
Бүгд л түүнийг асууж **сураглалаа**.

- Э.Г – ээр төгссөн үгэнд “л” дагавар залгасан.
- 3.Г – ээр төгссөн үгэнд “л” дагавар залгасан.
- Эгшгээр төгссөн үгэнд “л” дагавар залгасан.

- 11 Дараах үгсээс урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эгшиг нь гээгдэхгүй үгийг олж дугуялаарай.

ботго, намар, самбар, өдөр

- 12 “Сансар огторгуй” сэдвээр эх зохиож бичээрэй. Бичихдээ:



- 1.Өгсөн зураг болон түлхүүр үгсийг ашиглаарай.
- 2.Сансар огторгуйд байхад юу харагдаж, юу сонсогдож, юу мэдрэгдэх бол?
- 3.Төсөөлөн бодоод эхийн орчныг дүрслэн бичээрэй.

ур амьсгал, од, дэлхий, сансрын хөлөг, нисдэг таваг, сансрын нисгэгч, хиймэл дагуул, гайхалтай, гаргууд, бөмбөрцөг, тойрог зам, пуужин, жингүйдэл